



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2025/024/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086381
Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Э.Сүнжидмаа
Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолал, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 21 № 50

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал 18,000.0 мянган төгрөгийг урамшуулал хэлбэрээр олгосон,
- Төсвөөс 21,423.2 мянган тоног төхөөрөмж, хөрөнгө бэлтгэсэн боловч худалдан авах ажиллагаа зарлаагүй
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого 4,294.8 мянган төгрөгөөр зөрүүтэй хийгдсэн,

8225020124

- Төсвөөс 4,992.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй,
- Үр дүнгийн , урамшуулал, цалин 1,133,7 мянган төгрөгийг илүү тооцож олгосон,
- Цалингийн сангийн хэмнэлт болох 6,288.8 мянган төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүйгээр урамшуулал хэлбэрээр олгосон,
- Тухайн байгууллагын дансанд бүртгэлтэй 8,728.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дээд газрын шийдвэргүйгээр цагдаагийн газарт шилжүүлсэн,
- Санхүүгийн тайланд 7,784.9 мянган төгрөгийн олон жилийн насжилттай авлагын тооцоо нийлээгүй, барагдуулаагүй
- Тус байгууллагын дансанд бүртгэлтэй ерson 16490 бүртгэлтэй принтерийн зах зээлийн үнийн дүнгээс 2,410.0 мянган төгрөгөөр илүү бэлтгэсэн.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020-2024 оны ажлын тайланг хурлаар хэлэлцүүлж бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон. Мөн 2024-2028 онд ажиллах шинэ хурал бүрэлдэж Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн дагуу шинэ бүтцээр үйл ажиллагаа явуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгууллагын дансанд бүртгэлтэй 161,319.1 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр дуудлага худалдаагаар худалдан борлуулсан, 61,650.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн байна.

Бусад асуудал

Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 4 зорилт 6 арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,123,454.25</u>	<u>19,720,654.25</u>
33	АВЛАГА	7,784,964.25	16,382,164.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	195,213.25	6,992,413.25
335	Бусад авлага	7,589,751.00	9,389,751.00
33510	Байгууллагаас авах авлага	-	1,800,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	7,589,751.00	7,589,751.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,338,490.00	3,338,490.00
354	Хангамжийн материал	3,338,490.00	3,338,490.00
35410	Бичиг хэргийн материал	453,000.00	453,000.00
35420	Аж ахуйн материал	2,555,490.00	2,555,490.00
35470	Бусад хангамжийн материал	330,000.00	330,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,679,133.20</u>	<u>33,749,428.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,679,133.20	33,749,428.56
392	Биет хөрөнгө	13,657,883.10	33,749,428.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,685,750.00	45,858,950.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,856,366.40)	(19,063,466.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,047,000.00	16,960,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,218,500.50)	(10,006,055.08)
393	Биет бус хөрөнгө	21,250.10	-
39301	Програм хангамж	285,000.00	285,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(263,749.90)	(285,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>24,802,587.45</u>	<u>53,470,082.81</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>155,115.00</u>	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	155,115.00	-
413	Өглөг	155,115.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	135,115.00	-
4136	Бусад өглөг	20,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	20,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>24,647,472.45</u>	<u>53,470,082.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	24,647,472.45	53,470,082.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,613,124.40	4,613,124.40
51101	Өмч: - төрийн	4,613,124.40	4,613,124.40
512	Хуримтлагдсан үр дүн	20,034,348.05	48,856,958.41
51210	Өмнөх үеийн үр дүн	19,637,807.20	20,189,463.05
51220	Тайлант үеийн үр дүн	396,540.85	28,667,495.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>24,802,587.45</u>	<u>53,470,082.81</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	227,760,800.00	339,490,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	227,760,800.00	339,490,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	227,760,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	227,760,800.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	339,490,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	339,490,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	228,201,614.76	310,822,504.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	228,201,614.76	310,822,504.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,432,539.19	286,534,900.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,992,712.93	159,776,688.17
210101	Үндсэн цалин	70,848,818.70	84,821,389.80
210102	Нэмэгдэл	17,887,842.88	41,691,271.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,856,000.00	15,687,226.39
210104	Урамшуулал	8,400,051.35	17,576,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,965,792.50	14,143,600.00
210201	Тэтгэврийн даатгал	10,233,217.50	10,623,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	413,555.00	880,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	353,000.00	440,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	93,320.00	440,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	872,700.00	1,760,000.00
210401	Бичиг хэрэг	1,959,000.00	5,350,940.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	4,356,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	198,150.00	370,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	216,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	216,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	4,034,500.00	4,336,000.00
210702	Дотоод албан томилолт	4,034,500.00	4,336,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,549,169.00	66,101,418.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,549,169.00	66,101,418.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,017,214.76	32,100,204.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,896,400.00	20,764,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,990,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,120,814.76	6,344,904.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,769,075.57	24,287,603.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	(172,550.00)	22,807,584.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,841,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	(172,550.00)	1,966,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,941,625.57	-

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,941,625.57	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,480,019.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,480,019.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(440,814.76)</u>	<u>28,667,495.36</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(440,814.76)</u>	<u>28,667,495.36</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,613,124.40	25,923,635.37	30,536,759.77
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,613,124.40	25,923,635.37	30,536,759.77
3	Тайлант үеийн үр дүн	0.00	(440,814.76)	(440,814.76)
4	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,613,124.40	25,482,820.61	30,095,945.01
5	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,613,124.40	25,482,820.61	30,095,945.01
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	155,115.00	155,115.00
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,613,124.40	25,637,935.61	30,251,060.01
8	Тайлант үеийн үр дүн	0.00	28,667,495.36	28,667,495.36
9	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,613,124.40	54,305,430.97	58,918,555.37

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>227,760,800.00</u>	<u>339,490,000.00</u>
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	339,490,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	339,490,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>222,410,800.00</u>	<u>313,074,800.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	222,410,800.00	313,074,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	218,641,724.43	288,787,196.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	104,992,712.93	163,717,488.17

210101	Үндсэн цалин	70,848,818.70	88,762,189.80
210102	Нэмэгдэл	17,887,842.88	41,691,271.98
210103	Унаа хослны хөнгөлөлт	7,856,000.00	15,687,226.39
210104	Урамшуулал	8,400,051.35	17,576,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,965,792.50	17,000,000.00
210201	Тэтгэврийн даатгал	10,233,217.50	13,480,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	413,555.00	880,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	353,000.00	440,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	93,320.00	440,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	872,700.00	1,760,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,657,150.00	10,076,990.00
210401	Бичиг хэрэг	1,959,000.00	5,350,940.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	4,356,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	198,150.00	370,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	546,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	546,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	4,034,500.00	4,336,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	4,034,500.00	4,336,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,549,169.00	66,101,418.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,549,169.00	66,101,418.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,896,400.00	27,555,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,896,400.00	22,564,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,990,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,769,075.57	24,287,603.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	(172,550.00)	22,807,584.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,841,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	(172,550.00)	1,966,500.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,941,625.57	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,941,625.57	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,480,019.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,480,019.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,350,000.00</u>	<u>26,415,200.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,350,000.00	26,415,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,350,000.00	26,415,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,350,000.00	26,415,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,350,000.00	26,415,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,350,000.00)</u>	<u>(26,415,200.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-Орон нутгийн төсөв (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	341,560,000.0	339,934,700.0	1,625,300.0	99.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341,560,000.0	339,934,700.0	1,625,300.0	99.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	316,520,000.0	315,647,096.2	872,903.8	99.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,740,000.0	163,717,488.2	22,511.8	99.99
210101	Үндсэн цалин	100,740,000.0	88,762,189.8	11,977,810.2	88.11
210102	Нэмэгдэл	63,000,000.0	41,691,272.0	21,308,728.0	66.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	15,687,226.4	(15,687,226.4)	-
210104	Урамшуулал	-	17,576,800.0	(17,576,800.0)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,000,000.0	17,000,000.0	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	13,480,000.0	13,480,000.0	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	880,000.0	880,000.0	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	440,000.0	440,000.0	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	440,000.0	440,000.0	-	100.00

210205	Эрүүл мэндийн даатгал	1,760,000.0	1,760,000.0	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,504,000.0	10,076,990.0	427,010.0	95.93
210401	Бичиг хэрэг	5,604,000.0	5,350,940.0	253,060.0	95.48
210402	Тээвэр, шатахуун	4,400,000.0	4,356,000.0	44,000.0	99.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.0	370,050.0	129,950.0	74.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,500,000.0	26,415,200.0	84,800.0	99.68
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,500,000.0	21,423,200.0	76,800.0	99.64
210602	Тавилга	5,000,000.0	4,992,000.0	8,000.0	99.84
2107	Томилолт, зочны зардал	4,336,000.0	4,336,000.0	-	100.00
210702	Дотоод албан томилолт	4,336,000.0	4,336,000.0	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,440,000.0	66,101,418.0	338,582.0	99.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,440,000.0	66,101,418.0	338,582.0	99.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,000,000.0	28,000,000.0	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,000,000.0	23,000,000.0	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.0	5,000,000.0	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,040,000.0	24,287,603.8	752,396.2	97.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,480,019.8	(1,480,019.8)	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,480,019.8	(1,480,019.8)	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,040,000.0	22,807,584.0	2,232,416.0	91.08
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	22,970,000.0	20,841,084.0	2,128,916.0	90.73
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,070,000.0	1,966,500.0	103,500.0	95.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	341,560,000.0	339,934,700.0	1,625,300.0	99.52

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	341,560,000.0	339,934,700.0	1,625,300.0	99.52
132001	Орон нутгийн төсвөөс	341,560,000.0	339,934,700.0	1,625,300.0	99.52

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 10,196.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Жилийн эцсийн татварын тайлан, цалингийн дүнтэй тулгаж үзэхэд 119.6 мянган төгрөгөөр, эдийн засгийн ангилал 1,480.0 мянган төгрөгөөр,
- Цалингийн нөхөн олговор 3,940.8 мянган төгрөгөөр,
- Нийгмийн даатгалын шимтгэлийг 2,856.4 мянган төгрөгөөр, хувь хүний орлогын албан татварын 1,800.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 67,270.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 67,270.5 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрсэнд 4 албан шаардлага, 3 төлбөрийн актыг хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

1. Үр дүнгийн урамшуулал 869.7 мянган төгрөг, ажил хавсарсны нэмэгдэл 264.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", Есөнбулаг сумын ИТХ-ын даргын захирамж 2024 оны Б/03 дугаар тушаал "урамшуулал олгох тухай", Есөнбулаг сумын ИТХ-ын даргын захирамж 2024 оны Б/05 дугаар тушаал "урамшуулал олгох тухай", Есөнбулаг сумын ИТХ-ын даргын захирамж 2024 оны Б/05 дугаар тушаал "урамшуулал олгох тухай", Есөнбулаг сумын ИТХ-ын даргын захирамж 2024 оны Б/11 дугаар тушаал "урамшуулал олгох тухай" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3. Тус байгууллагын дансанд бүртгэлтэй epson l6490 бүртгэлтэй принтерийн зах зээлийн үнийн судалгааг PC mall, Segu цахим сайтаас 1,799.0-1,840.0 мянган төгрөгийн хооронд байна. Иймд зах зээлийн ханшнаас 2,410.0 мянган төгрөгөөр илүү бэлтгэсэн нь Нягтлан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг 18,000.0 мянган төгрөгийг урамшуулал хэлбэрээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын хавсралт "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7-т "Төлөөлөгчийн үйл ажиллагаа, чадавхжуулах арга хэмжээнд шаардагдах зардлын төсвийг сар, улирлаар хуваарилах бөгөөд урьд олгогдсон төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн баримт, тайланг бүрэн гаргасны дараа төлөөлөгчийн бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн дараагийн сар, улирлын төсөвт зардлыг тухай бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаж албан шаардлага хүргүүлсэн.


2. Багаж техник худалдан авах зардлаас 21,423.2 мянган тоног төхөөрөмж, хөрөнгө бэлтгэсэн боловч худалдан авах ажиллагаа зарлаагүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Босго үнээс давсан зардал хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулах албан шаардлага хүргүүлсэн.

3. Төсвөөс 4,992.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Цахим дэлгүүрт байршсан тавилга эд хогшил худалдан авах ажиллагаа зохион байгуулах зөрчлийг арилгаж албан шаардлага хүргүүлсэн.

4. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор ажилчдын карттай тулгаж үзэхэд 956.3 мянган төгрөгөөр зөрүүтэй, 3,338.5 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.



5. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого 4,294.8 мянган төгрөгөөр зөрүүтэй хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Хөрөнгийн тооллого хийж үр дүнг удирдлагын хэмжээнд хэлэлцэж тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлсэн.

6. Тухайн байгууллагын дансанд бүртгэлтэй 8,728.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дээд газрын шийдвэргүйгээр цагдаагийн газарт шилжүүлсэн

Шийдвэрлэлт: Хөрөнгийг хэрэгцээ шаардлагатай газарт нь журмын дагуу шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах арилгах албан шаардлага хүргүүлсэн

7. Санхүүгийн тайланд 7,784.9 мянган төгрөгийн олон жилийн насжилттай авлагын тооцоо нийлээгүй, барагдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн

8. Байгууллагын ажилчдад цалингийн сангийн хэмнэлт болох 6,288.8 мянган төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүйгээр урамшуулал хэлбэрээр олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэлт: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй	
										тоо	Дүн	тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
	Жилийн эцсийн татварын тайлан, цалингийн дүнтэй тулгаж үзэхэд 119.6 мянган төгрөгөөр, эдийн засгийн ангилал 1,480.0 мянган төгрөгөөр	1	1,599.6	-	-	1	1,599.6	1	1,599.6	-	-	-	-
Байгаль орчны газар	Цалингийн нөхөн олговор 3,940.8 мянган төгрөгөөр,	1	3,940.8			1	3,940.8	1	3,940.8				
	Нийгмийн даатгалын шимтгэлийг 2,856.4 мянган төгрөгөөр, хувь хүний орлогын албан татварын 1,800.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан	1	4,656.4			1	4,656.4	1	4,656.4				
Дүн		1	10,196.8			1	10,196.8	1	10,196.8	1	10,196.8	-	-



4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал 18,000.0 мянган төгрөгийг урамшуулал хэлбэрээр олгосон	1	18,000.0	-	-	1	18,000.0	-	-	-	-
	Төсвөөс 21,423.2 мянган тоног төхөөрөмж, хөрөнгө бэлтгэсэн боловч худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.	1	21,423.2	-	-	1	21,423.2	-	-	-	-
	Төсвөөс 4,992.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	4,992.0	-	-	-	1	4,992.0	-	-	-
	Жилийн эцсийн хөрөнгийн тооллого 4,294.8 мянган төгрөгөөр зөрүүтэй хийгдсэн	1	4,294.8	-	-	-	1	4,294.8	-	-	-
Санхүүгийн тайланд 7,784.9 мянган төгрөгийн олон жилийн насжилттай авлагын тооцоо нийлээгүй, барагдуулаагүй байна	Тухайн байгууллагын дансанд бүртгэлтэй 8,728.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дээд газрын шийдвэргүйгээр цагдаагийн газарт шилжүүлсэн	1	7,784.9	-	-	1	7,784.9	-	-	-	-
		1	8,728.0	-	-	1	8,728.0	-	-	-	-



Үр дүнгийн урамшуулал 869.7 мянган төгрөг, ажил хавсарсны нэмэгдэл 264.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон	1	1,133.7	1	1,133.7	-	-	-	-	-
Цалингийн сангийн хэмнэлт болох 6,288.8 мянган төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүйгээр урамшуулал хэлбэрээр олгосон	1	6,288.8	-	6,288.8	1	6,288.8	-	-	-
Тус байгууллагын дансанд бүртгэлтэй ерson 16490 бүртгэлтэй принтерийн зах зээлийн үнийн судалгааг PC mall, Segu цахим сайтаас 1,799.0-1,840.0 мянган төгрөгийн хооронд байна. Иймд зах зээлийн ханшнаас 2,410.0 мянган төгрөгөөр илүү бэлтгэсэн байна.	1	2,410.0	1	2,410.0	-	-	-	-	-
Дүн	9	67,270.5	2	3,543.7	6	63,726.8	-	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Шилэн дансанд байршуулах төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 32,808.2 мянган төгрөгийн 16 мэдээллээс, 27,270.0 мянган төгрөгийг 5 мэдээллийг мэдээлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-
Нийт		1	-	-	-	1	-	-	-	-	-



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1				1			
	НИЙТ		1				1			

